



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

2024 оны 05 дугаар сарын 17

Дугаар 204/03-60

Улаанбаатар хот

“ИНТЕЛЛЕКТ ТАУЭР ХХК”-д

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт, 40, 50 мянгат-2 /15171/ бүсчлэлд Улаанбаатар хотын төлөвлөлтийн бүсийн 6 дугаар нэгж хороолол, Жуулчны гудамж дагуу байршуулан Үйлчилгээ ногоон байгууламж, тохижилт бүхий газар доорх нийтийн хэрэгцээний авто зогсоол зориулалтаар эзэмшүүлсэн 1.38 га газарт.

2. Зураг төслийн компани: “интеллект тауэр” ХХК, 01/24-ИТ

3. Барилга байгууламжийн зориулалт: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ы өдрийн А/275 дугаар захирамжтай, “Нийслэлийн Засаг даргын тамгын газар”-т Дээрээ тохижилт бүхий газар доорх автозогсоол, үйлчилгээний цогцолбор барилгын зориулалтаар 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр нийслэлийн ерөнхий архитекторын баталсан архитектур төлөвлөлтийн МЗХ2024/00-103 тоот даалгавартай, Батлагдсан эскиз зурагтай.

4. Барилга байгууламжийн давхар, талбай: -1 Зоорьтой, А, В, С, D блок.

5. Галд тэсвэршилтийн зэрэг: Төлөвлөсөн II

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф5.2, Ф3.1

7. Зургийн иж бүрдэл: 2 хэсэг

Хоёр. Барилга байгууламжийн зураг
төслийн галын аюулгүй байдал

1. Гал түймэр унтраах даралтат хоолойн холболт нь ГОСТ 28352 ба НПБ 153 /1/ шаардлагуудыг хангасан байна. /Зургийн тайлбар хэсэгт Галын дотор даралтад усны цэгийн /кран/ холбох тотгыг Богданов төрлийн холбох хэрэгслээр тоноглох гэж оруулах/

2. Шатны хонгилд байрлах хаалга нь гал тэсвэршлэх нягтруулагч, өөрөө хаагддаг төхөөрөмжөөр тоноглогдсон байх. /Хэсэгчлэл зурагт хаалганы төрлийг оруулах/.

Гурав. Ерөнхий дүгнэлт

Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Хянасан сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2024.05.17	Нүүр хуудас БА 103-115, ХАС 19-27, ЦБУ 2-13, ХД 4-11,	Барилгын ажлын зураг төслийн дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН.
ЗУРАГ, ХЯНАЛТЫН ТАСГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Б.МЯГМАРЖАВ

0000-1933